

**ШУТИС-ИЙН ХАРЬЯА ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН АХЛАХ СУРГУУЛИЙН
БАГШИЙН АЖЛЫГ ҮНЭЛЭХ, ДҮГНЭХ ЖУРАМ**

Боловсруулсан:

ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль

Хянасан:

**ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн
захирлын зөвлөл**

Дэмжсэн:

ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах багш нарын зөвлөл

Баталсан:

**ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн
захирал**

ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирлын 2022 оны 10 сарын 02 өдрийн 1/04 дугаар тушаалын тавдугаар хавсралт



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Багшийн ажлыг үнэлэх, дүгнэхтэй холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Багшийн ажлыг суралцагчийн хөгжил, хамгааллын үр дүн болон хүчин төгөлдөр мөрдөж буй багшийн албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, үр дүнгээр үнэлж дүгнэнэ.
- 1.3. Багшийн ажлыг үнэлэх, дүгнэх үйл ажиллагаа /цаашид "багшийн ажлын үнэлгээ" гэх/-ны зорилго нь багшийн ажлын чанар, сургалтын үр дүнг үнэлж, багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, өөрийн үйл ажиллагааны гүйцэтгэлээ удирдах, хариуцлагатай хандах соёлыг төлөвшүүлэх, улмаар сургалтын чанарыг сайжруулахад оршино.
- 1.4. Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх үйл ажиллагааг сургуулийн захиргаанаас удирдлагаар хангаж, явцын хяналт тавьж ажиллана.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Сургуулийн захирлын тушаалаар батлагдсан үндсэн орон тоонд ажилладаг багш, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

ГУРАВ. БАГШИЙН АЖЛЫН ҮНЭЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 3.1 Багшийн ажлын үнэлгээг зохион байгуулахад доор дурдсан зарчмыг баримтална.
 - 3.1.1. Ил тод, шударга, бодитой байх;
 - 3.1.2. Үр дүн, нотолгоонд суурилсан байх;
 - 3.1.3. Хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх;
 - 3.1.4. Багшийн нэр хүндийг хүндэтгэсэн байх;
 - 3.1.5. Багшийн өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзлийг дэмжсэн байх;
 - 3.1.6. Нээлттэй, үнэлгээний олон арга хэлбэрийг хослуулсан байх.


ДӨРӨВ. БАГШИЙН АЖЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 4.1 Багшийн ажлын тайланг хагас жил, бүтэн жилээр хэлэлцэж, дүгнэнэ.
- 4.2 Хичээлийн жилийн ажлын үзүүлэлтээр тэргүүлсэн багшийг "Шилдэг багшаар" шалгаруулж 1 сарын үндсэн цалингийн урамшуулал олгоно.

ТАВ. БУСАД

- 5.1 Үндсэн багш нар Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн А/430 дугаар тушаалын дагуу ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэж, дүгнэх журмын дагуу багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдаж үнэлгээний үр дүнд үндэслэн багшид Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолд заасан мөнгөн урамшууллыг доор дурдсан хувь хэмжээгээр албан тушаалын сарын үндсэн цалингаас тооцож хичээлийн жилд нэг удаа олгоно. (Хүснэгт 2)
- 5.2 Багш 2 ба түүнээс дээш удаа 60%-с доош үнэлгээтэй үнэлэгдвэл хөдөлмөрийн дотоод журмын 9.2.8.3-т зааснаар шийдвэрлэнэ. (Хүснэгт 1)

ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирлын /М/ Оны /А/ сарын /О/ өдрийн /А/ дугаар тушаалын тавдугаар хавсралт



Хүснэгт 1. Үнэлгээний индекс

Индексийн түвшин	Тухайн кластер дахь цэцэрлэг/сургуулийн эрэмбийн хувь /N/
I түвшин	$95 \leq N$
II түвшин	$85 \leq N < 95$
III түвшин	$70 \leq N < 85$
IV түвшин	$60 \leq N < 70$
V түвшин	$N \leq 60$

Хүснэгт 2. Урамшуулал тооцох тухай

Тухайн кластер дахь багшийн эрэмбийн хувь /M/	Албан тушаалын сарын үндсэн цалингаас урамшуулал тооцож олгох хувь
$95 \leq M$	25 %
$85 \leq M < 95$	20 %
$75 \leq M < 85$	15 %
$60 \leq M < 75$	10 %

5.3 Багш 2 ба түүнээс дээш удаа 60%-с доош үнэлгээтэй үнэлэгдвэл хөдөлмөрийн дотоод журмын 9.2.8.3-т зааснаар шийдвэрлэнэ.

5.4 Багшийн ажлыг үнэлэх дүгнэх, урамшуулал олгохтой холбогдон гарах маргааныг захирлын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

Хавсралт 1: Багшийн ажлын үнэлгээний үр дүнг тооцох

№	Үнэлгээний бүлэг (түлхүүр үзүүлэлт)	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо	Үзүүлэлт тус бүрийн биелэлтийн оноо	Нийт бодит гүйцэтгэл оноо
				Өөрийн үнэлгээ	
1	Төлөвлөгөөт ажил (50%)	Албан тушаалын тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийг гүйцэтгэсэн байдал	50		
2	Тусгай ажл (30%)	Тайлан, мэдээ мэдээллийг хугацаанд нь гаргасан байдал	5		
3		Сургалтын үйл ажиллагаанд дэвшилтэт арга зүй, технологи нэвтрүүлсэн, ашигласан, нутагшуулахад чиглэсэн үйл ажиллагаа;	5		
4		Ном сурах бичиг, гарын авлага хэвлүүлсэн;	5		
		Онцгой үүрэг, даалгавар биелүүлсэн байдал (Сургуулийн тавьсан зорилго, зорилтыг			

ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирлын 2015 оны 01 сарын 04 өдрийн А/04 дугаар тушаалын тавдугаар хавсралт



5		хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагаас тусгайлан даалгасан үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал)	5		
		Олимпиад уралдаан, тэмцээнд өөрөө болон суралцагчдаа бэлтгэн оролцуулсан байдал, гаргасан амжилт.	5		
6		Кабинет, анги танхимын үйл ажиллагаа	5		
7	Хувь хүний чадамж (20%)	Мэргэжил, ур чадвар, хувь хүний хөгжлөө дээшлүүлсэн байдал;; - Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан; - Эрдмийн зэрэг хамгаалсан, Эрдмийн цол хүртсэн;	5		
8		Ажлын байрны цаг ашиглалтын байдал	2		
9		Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил бичсэн, хэлэлцүүлсэн, хэвлүүлсэн байдал	3		
10		Ёс зүйн хэм хэмжээг баримталж ажилласан байдал	3		
11		Суралцагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	2		
		Удирдлагаас өгсөн, хугацаатай үүрэг даалгаврын биелэлт, шууд удирдлагын үнэлгээ	5		


Хавсралт 2: Заах аргач зэрэгтэй багшийн ажлын үнэлгээний үр дүнг тооцох

№	Үнэлгээний бүлэг (түлхүүр үзүүлэлт)	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо	Үзүүлэлт тус бүрийн биелэлтийн оноо	Нийт бодит гүйцэтгэл оноо
				Өөрийн үнэлгээ	
1		Сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийг төлөвлөн үр дүнтэй зохион байгуулдаг байх	10		
2		Хариуцлагатай, шударга, хамт олон, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчидтэй эерэг харилцаатай байх	5		



3	Мэргэжлийн зэргийн шалгуур хангасан байдал (50%)	Явцын үнэлгээг тогтмол хэрэгжүүлдэг, үр дүнд үндэслэн арга зүйгээ сайжруулдаг байх	5		
4		Боловсролын цахим, нээлттэй нөөцийг ашиглан сургалтын цахим хэрэглэгдэхүүн үнэлгээг хичээл, сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх	5		
5		Судалгаат хичээл зохион байгуулж, хичээлийн судалгаанд хувь нэмэр оруулсан байх	5		
6		Сургалтын үйл ажиллагааг сайжруулахад бусад багш нартай идэвх, санаачилгатай хамтран ажилладаг байх, хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжих чиглэлээр хичээлээс гадуурх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулдаг байх	5		
7		Мэргэжлийн багш нарын бүлэг, багийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог байх, хүүхдийн эрхийг хамгаалах, суралцагчдын хөгжил төлөвшлийг дэмжих, үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхал, хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, суралцагчдын хөгжил төлөвшлийг дэмжихэд багш, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажилладаг байх	5		
8		Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дү, багшийн хөгжих хэрэгцээнд үндэслэн багшийн хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөн үр дүнтэй хэрэгжүүлдэг байх	10		
9		Тайлан, мэдээ мэдээллийг хугацаанд нь гаргасан байдал	5		
10	Тусгай ажил (30%)	Сургалтын үйл ажиллагаанд дэвшилтэт арга зүй, технологи нэвтрүүлсэн, ашигласан, нутагшуулахад чиглэсэн үйл ажиллагаа;	5		
11		Ном сурах бичиг, гарын авлага хэвлүүлсэн;	5		
12		Онцгой үүрэг, даалгавар биелүүлсэн байдал (Сургуулийн тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагаас тусгайлан даалгасан үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал)	5		

ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирлын 2025 оны 01 сарын 01 өдрийн А.04 дугаар тушаалын тавдугаар хавсралт



13		Олимпиад уралдаан, тэмцээнд өөрөө болон суралцагчдаа бэлтгэн оролцуулсан байдал, гаргасан амжилт.	5		
14		Кабинет, анги танхимын үйл ажиллагаа	5		
15	Хувь хүний чадамж (20%)	Мэргэжил, ур чадвар, хувь хүний хөгжлөө дээшлүүлсэн байдал.; - Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан; - Эрдмийн зэрэг хамгаалсан, Эрдмийн цол хүртсэн;	5		
16		Ажлын байрны цаг ашиглалтын байдал	2		
17		Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил бичсэн, хэлэлцүүлсэн, хэвлүүлсэн байдал	3		
18		Ёс зүйн хэм хэмжээг баримталж ажилласан байдал	3		
19		Суралцагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	2		
20		Удирдлагаас өгсөн, хугацаатай үүрэг даалгаврын биелэлт, шууд удирдлагын үнэлгээ	5		

Хавсралт 3: Тэргүүлэх зэрэгтэй багшийн ажлын үнэлгээний үр дүнг тооцох

№	Үнэлгээний бүлэг (түлхүүр үзүүлэлт)	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо	Үзүүлэлт тус бүрийн биелэлтийн оноо	Нийт бодит гүйцэтгэл оноо
				Өөрийн үнэлгээ	
1		Сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийг төлөвлөн үр дүнтэй зохион байгуулдаг байх	10		
2		Хариуцлагатай, шударга, хамт олон, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчидтэй эерэг харилцаатай байх	5		
3		Явцын үнэлгээг тогтмол хэрэгжүүлдэг, үр дүнд үндэслэн арга зүйгээ сайжруулдаг байх	5		
4		Боловсролын цахим, нээлттэй нөөц, хэрэглэгдэхүүн, үнэлгээг бүтээлчээр хэрэглэдэг, орон нутгийн түвшинд арга зүй, туршлагаа хуваалцдаг байх	5		

ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирлын 2015 оны 8 сарын 24 өдрийн А/Д.4 дугаар тушаалын тавдугаар хэвсрэлт



5	Мэргэжлийн зэргийн шалгуур хангасан байдал (50%)	Шинэлэг бүтээлч арга зүй, технологийг турших, хэрэгжүүлэх зорилгоор хичээлийн судалгааг зохион байгуулж, үр дүнг сургууль, орон нутгийн түвшинд хэлэлцүүлсэн байх	5		
6		Сургалтын чанар, үр дүнг сайжруулахад бусад багш нартай хамтран ажиллаж, арга зүй, туршлагаа сургууль, бүсийн түвшинд хуваалцдаг байх	5		
7		Хүүхдийн авьяас, чадвар, хөгжих хэрэгцээг судалж, илрүүлэн, хөгжүүлэх үйл ажиллагааг санаачлан зохион байгуулдаг байх	5		
8		Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүн, багшийн хөгжих хэрэгцээнд үндэслэн багшийн хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөн үр дүнтэй хэрэгжүүлдэг байх	10		
9	Тусгай ажил (30%)	Тайлан, мэдээ мэдээллийг хугацаанд нь гаргасан байдал	5		
10		Сургалтын үйл ажиллагаанд дэвшилтэт арга зүй, технологи нэвтрүүлсэн, ашигласан, нутагшуулахад чиглэсэн үйл ажиллагаа;	5		
11		Ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлсэн;	5		
12		Онцгой үүрэг, даалгавар биелүүлсэн байдал (Сургуулийн тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагаас тусгайлан даалгасан үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал)	5		
13		Олимпиад, уралдаан, тэмцээнд өөрөө болон суралцагчдаа бэлтгэн оролцуулсан байдал, гаргасан амжилт.	5		
14		Кабинет, анги танхимын үйл ажиллагаа	5		
15		Мэргэжил, ур чадвар, хувь хүний хөгжлөө дээшлүүлсэн байдал.;	5		
		- Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан;			
16		- Эрдмийн зэрэг хамгаалсан, Эрдмийн цол хүртсэн;			
		Ажлын байрны цаг ашиглалтын байдал	3		

ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирлын 2015 оны 11 сарын 24 өдрийн А/Д/Х дугаар тушаалын тавдугаар хавсралт



17	Хувь хүний чадамж (20%)	Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил бичсэн, хэлэлцүүлсэн, хэвлүүлсэн байдал	3		
18		Ёс зүйн хэм хэмжээг баримталж ажилласан байдал	2		
19		Суралцагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	2		
20		Удирдлагаас өгсөн, хугацаатай үүрэг даалгаврын биелэлт, шууд удирдлагын үнэлгээ	5		

Хавсралт 4: Зөвлөх зэрэгтэй багшийн ажлын үнэлгээний үр дүнг тооцох

№	Үнэлгээний бүлэг (түлхүүр үзүүлэлт)	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо	Үзүүлэлт тус бүрийн биелэлтийн оноо	Нийт бодит гүйцэтгэл оноо
				Өөрийн үнэлгээ	
1	Мэргэжлийн зэргийн шалгуур хангасан байдал (50%)	Сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийг төлөвлөн үр дүнтэй зохион байгуулдаг байх	10		
2		Хариуцлагатай, шударга, хамт олон, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчидтэй эерэг харилцаатай байх	5		
3		Явцын үнэлгээг тогтмол хэрэгжүүлдэг, үр дүнд үндэслэн арга зүйгээ сайжруулдаг байх	5		
4		Боловсролын цахим, нээлттэй нөөцийг бүрдүүлэхэд орон нутаг, үндэсний түвшинд хувь нэмэр оруулсан байх	5		
5		Шинэлэг бүтээлч арга зүй, технологийг турших, хэрэгжүүлэх зорилгоор хичээлийн судалгааг манлайлан зохион байгуулж, үр дүнг орон нутаг, бүс үндэсний түвшинд хуваалцсан байх	5		
6		Орон нутгийн боловсрол, сургалтын байгууллагатай хамтран ажиллаж, арга зүй, туршлагаа бүс, үндэсний түвшинд хуваалцдаг байх	5		
7		Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлсэн арга зүй, туршлагаа бүс, үндэсний түвшинд хуваалцдаг байх.	5		
		Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дү, багшийн хөгжих	10		

ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирлын 2015 оны 2 сарын 26 өдрийн 2/04 дугаар тушаалын тавдугаар хэсрэлт



8		хэрэгцээнд үндэслэн багшийн хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөн үр дүнтэй хэрэгжүүлдэг байх			
9	Тусгай ажил (30%)	Тайлан, мэдээ мэдээллийг хугацаанд нь гаргасан байдал	5		
10		Сургалтын үйл ажиллагаанд дэвшилтэт арга зүй, технологи нэвтрүүлсэн, ашигласан, нутагшуулахад чиглэсэн үйл ажиллагаа;	5		
11		Ном сурах бичиг, гарын авлага хэвлүүлсэн;	5		
12		Онцгой үүрэг, даалгавар биелүүлсэн байдал (Сургуулийн тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагаас тусгайлан даалгасан үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал)	5		
13		Олимпиад уралдаан, тэмцээнд өөрөө болон суралцагчдаа бэлтгэн оролцуулсан байдал, гаргасан амжилт.	5		
14		Кабинет, анги танхимын үйл ажиллагаа	5		
15	Хувь хүний чадамж (20%)	Мэргэжил, ур чадвар, хувь хүний хөгжлөө дээшлүүлсэн байдал.; - Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан; - Эрдмийн зэрэг хамгаалсан, Эрдмийн цол хүртсэн;	5		
16		Ажлын байрны цаг ашиглалтын байдал	3		
17		Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил бичсэн, хэлэлцүүлсэн, хэвлүүлсэн байдал	3		
18		Ёс зүйн хэм хэмжээг баримталж ажилласан байдал	2		
19		Суралцагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	2		
20		Удирдлагаас өгсөн, хугацаатай үүрэг даалгаврын биелэлт, шууд удирдлагын үнэлгээ	5		